

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ**

2024 оны 11 сарын 07-ны өдөр

Дугаар: 41/2024

Мандалговь хот

Нэг. Удиртгал хэсэг

Дундговь аймгийн Баянжаргалан сумын гудамж хороололд гэрэлтүүлэг хийх ажилд Дундговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн А/57 дугаар тушаалын дагуу байгуулагдсан 7 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга угсралтын ажил, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний дугаар:

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар: ЗТ-03/2024;

2.3. Захиалагч: Дундговь аймгийн Баянжаргалан сумын ЗДТГ, регистрийн дугаар: 9033602, Хаяг: Дундговь аймаг, Баянжаргалан сум, 3-р баг, Дөш-4 гудамжны 406 тоот, сумын ЗДТГ-ын байр, холбоо барих утас: 88094414;

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: "Анарзоне" ХХК, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9011310094, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар: 749/23, Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 16-р хороо, 16-р хороолол, 34-32 тоот, холбоо барих утас: 99099501;

2.5. Барилгын ажлын туслан гүйцэтгэгч: байхгүй;

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: "Кристал Би Би И Эл" ХХК, регистрийн дугаар: 6971962, зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар: ЗТ18-198/23, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Sunroad оффис, 4 давхарт, холбоо барих утас: 89145146;

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Дундговь аймгийн Баянжаргалан сумын ЗДТГ, регистрийн дугаар: 9033602, Хаяг: Дундговь аймаг, Баянжаргалан сум, 3-р баг, Дөш-4 гудамжны 406 тоот, сумын ЗДТГ-ын байр, холбоо барих утас: 88094414;

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: Баянжаргалан сумын гудамж хорооллын гэрэлтүүлгийн ажлыг батлагдсан ажлын зураг төсөл болон холбогдох БНБД-ийн дагуу гүйцэтгэсэн.

Гурав. Дүгнэлтийн хэсэг

Барилга байгууламж ашиглалтанд оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжинд заасан шаардлагыг хангасан тул

Барилга байгууламж ашиглалтанд оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжинд заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангагдаагүй тул

3.1. Энэ Бага төвөгшилтэй ангиллын, Баянжаргалан сумын гудамж хорооллын гэрэлтүүлгийн ажил түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсөний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад орох болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а). Барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад 14 хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б). Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3. Ашиглагч байгууллагад:

а). Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хууль тогтоомжид заасан дуусгавар болгоход оролцох;

б). Барилга байгууламжийн хувийн хэргийн хөтөлж эхлүүлэх;

в). Барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой тогтоомжын хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалг иж байна.


3.4. Комиссын акт хуудас, хуралдааны тэмдэглэл хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. Баянжаргалан сумын гудамж хорооллын гэрэлтүүлгийн ажлыг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Комиссын дарга:

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга



/Э.Энхмэнд/

Нарийн бичгийн дарга:

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн

/Э.Дүүрэнжаргал/

- ❖ Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан Барилга байгууламж ашиглалтанд оруулах дүрмийн 4 дүгээр хавсралтын хамт хүчинтэй.

Хавсралт хуудастай.

**ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН ГУДАМЖ ХОРООЛЛЫН
ГЭРЭЛТҮҮЛГИЙН АЖЛЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2024.10.29

Баянжаргалан сум

Дундговь аймгийн ГХБХБГ-ын даргын 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/58 дугаар тушаалаар байгуулагдсан 7 хүний бүрэлдэхүүнтэй Баянжаргалан сумын гудамж хорооллын гэрэлтүүлгийн ажлыг ашиглалтад оруулах комиссын хурал 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 17.30 цагт сумын Засаг даргын өрөөнд эхлэв.

Хурлыг комиссын дарга Э.Энхмэнд нээж барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс томилсон тушаалыг танилцуулав.

Комиссын бүрэлдэхүүнд:

Комиссын дарга

Э.Энхмэнд /Аймгийн ГХБХБГ-ын БХБХ-ийн дарга/

Комиссын нарийн бичгийн дарга

Э.Дүүрэнжаргал /Аймгийн ГХБХБГ-ын БХБХ-ийн мэргэжилтэн/

Комиссын гишүүд

Р.Отгонбаатар /Баянжаргалан сумын ЗДТГ-ын дарга/-ыг орлож багийн дарга Б.Пүрэвбаяр

М.Оргил /Зураг төсөл зохиогч "Кристал Би Би И Эл ХХК-ийн инженер/ цахимаар оролцов.

Т.Отгоншагай /Гүйцэтгэгч "Анарзоне" ХХК-ийн захирал/

З.Ганбаяр /БЗӨБЦТС ТӨХК-ийн Говьсүмбэр ЦТСС-ын Баянжаргалан сумын засварын техникч/

Т.Уранбайгаль /Аймгийн ЗДТГ-ын Архивын тасгийн дарга/

Хэлэлцэх асуудал:

Дундговь аймгийн Баянжаргалан сумын гудамж хорооллын гэрэлтүүлгийн ажлыг ашиглалтад оруулах комисс ажиллах.

Барилга байгууламжийн талаар:

Баянжаргалан сумын гудамж хорооллын гэрэлтүүлгийн угсралтын ажил, гүйцэтгэлийн баримт бичиг, барилгын усгалтын ажилтай газар дээр нь танилцаж, гүйцэтгэгч байгууллагаас ажлын талаар, зураг төсөл зохиогчийн дүгнэлт, захиалагч хяналт гүйцэтгэгч байгууллагаас захиалагчийн хяналтын нэгдсэн дүгнэлтийг тус тус танилцуулав.

Дээрх танилцуулга хийгдсэний дараа комиссын гишүүдээс барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах эсэх талаар гишүүдийн санал асуулга эхэллээ.

Хэлэлцсэн нь:

Э.Энхмэнд:

Комиссын гишүүд засварын ажил болон зурагт төсөл, холбогдох бусад бичиг баримттай танилцаж дууссан тул хуралд оруулах саналаа хэлнэ үү.

Б.Пүрэвбаяр:

Гэрлийн шонгийн суурь болох 50 см бетоныг дүүргэх. Баруун хойд хэсгийн цамхагт гэрэлтүүлгийн тэжээлийн эх үүсвэрийг солих. Хазайсан гэрэлтүүлгийг тэгшлэх. Баталгаат хугацаанд гарсан зөрчлийг засварлах. Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад хүлээн авах саналтай байна.

З.Ганбаяр:

Гэрэлтүүлгийн ажил батлагдсан зураг төслийн дагуу хийгдсэн тул хангагч байгууллагын зүгээс ашиглалтад хүлээн авах саналтай байна.

Т.Уранбайгаль:

Гүйцэтгэлийн баримт бичгийн эх хувийг төрийн архивт шилжүүлэх, баримт бичгийг дүрэм журмын дагуу цэгцлэх, хуудас дугаарлах, дотоод товъёог, баталгааны хуудас бичих. Баримт бичгийг хавтаслаж, хамгаалалтын хайрцагт хийж өгөх. Ашиглалтад хүлээн авах саналтай байна.

Э.Дүүрэнжаргал:

Бичиг баримтын бүрдлийг сайтар хангах. Нормчлолын сангийн мөнгийг тушаах. Үүрэг даалгаварын биелэлтээр ашиглалтад хүлээн авах саналтай байна.

Т.Отгоншагай:

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврыг хурдан хугацаанд чанартай хийж гүйцэтгэн ашиглалтад хүлээлгэн өгөх саналтай байна.

Э.Энхмэнд:

Гэрэлтүүлгийн гүйцэтгэлийн зураглалыг хийлгэж хот байгуулалтын мэдээллийн санд хүлээлгэн өгөх. Үүрэг даалгаварын биелэлтээр ашиглалтад хүлээн авах саналтай байна.

КОМИССИЙН ШИЙДВЭР:

Комиссын гишүүдээс ашиглалтад хүлээн авахаас татгалзсан саналтай гишүүн байхгүй тул гишүүдийн үүрэг даалгаварын биелэлтээр ашиглалтад хүлээн авахаар шийдвэрлэлээ.

Комиссын хурал 18.20 цагт дуусав.

Танилцсан:

ГХБХБГ-ын БХБХ-ийн дарга



Э.Энхмэнд

Тэмдэглэл хөтөлсөн:

ГХБХБГ-ын БХБХ-ийн мэргэжилтэн



Э.Дүүрэнжаргал